

**“ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, Төсвийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч Ойрх Дорнодод үүссэн нөхцөл байдлын улмаас дэлхийн зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, үнэд эрс нөлөөлж, үнийн түвшний өсөлт бий болох эрсдэл өндөр байгаатай холбогдуулан өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох автобензиний гаалийн албан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас тогтоосон хязгаарт багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгох, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгож байгаа нь газрын тосны дайвар бүтээгдэхүүний үнийг бууруулж, хуурамч шатахууны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан манай улсын шатахууны нийт хэрэглээний хэдэн хувийг дизель түлш, хэдэн хувийг АИ-92 автобензин эзэлж байгааг тодруулж, дээрх үнийн өсөлтөөс хамааран аж ахуйн нэгж, иргэдэд үүсэх хүндрэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин хаврын тариалалт эхэлж байгаа энэ үед тариалан эрхлэгчид нэг тонн дизель түлшийг хэдэн төгрөгөөр худалдан авах, мөн манай улсын дизель түлшний нөөцийн хэмжээ болон хомсдол үүсэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал гаалийн албан татвар нь дотоодын зах зээлд үндэсний үйлдвэрлэлээ хамгаалдаг тохируулгын татвар бөгөөд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтөөс аж ахуйн нэгж, ард иргэдээ хамгаалах зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг Улсын Их Хурлаас тогтоосон хязгаарт багтаан тогтоох эрхийг Засгийн газарт олгох нь

зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг манай улсын уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа нь газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хангамжаас хамааралтай тул тэдгээрийн төсөв, зардлын хэмжээ хэлбэлзэх эрсдэлтэй байгааг анхаарч, цаашид эдгээр салбаруудад ногоон шилжилт хийх асуудлыг төрөөс бодлогоор дэмжих нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа дэлхийн зах зээл дээр газрын тосны үнийн өсөлт нь манай улсын эдийн засагт нөлөөлөх тул энэ эрсдэлээс иргэд, аж ахуйн нэгжийг хамгаалахад төрөөс тодорхой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй, мөн энэ үнийн өсөлт нь төсөвт урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас тодотгол хийх нөхцөл үүсэж байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн 63.2 хувь буюу олонх дэмжиж, хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР